

СПОРТ, НИЙТИЙН БИЕЙН ТАМИРЫН ХЭЛТЭС

БИЕЙН ТАМИРЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ДЭЛГЭРГҮЙ ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсээс 2025 оны эхний хагас жилийн байдлаар биеийн тамирын 9 арга хэмжээ зохион байгуулж 303 байгууллагын 115958 иргэнийг хамруулж улсын төсвөөс 6,445,000 төгрөг, Нийслэлийн төсвөөс 982,337,200 төгрөг, нийт 988,782,200 төгрөгийг зарцуулсан байна.

Нийслэл, дүүргийн хэмжээнд 177 удаагийн биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулж, 3989 байгууллагын 608,401 иргэдийг хамруулж Улсын төсвөөс 207,495,800 төгрөг, Нийслэлийн төсөв 1,255,205,800 төгрөг, бусад төсөв 8,400,000 төгрөг, нийт 1,471,101,600 төгрөгийг зарцуулсан байна.

БИЕЙН ТАМИР, СПОРТЫН КЛУБ

Нийслэлийн хэмжээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар 820 биеийн тамир, спортын хамтлаг үйл ажиллагаагаа тогтмолжуулан ажиллаж байна. Биеийн тамир, спортын хамтлагийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, нийтэд таниулах, урамшуулах зорилгоор Нийслэлийн шилдэг биеийн тамир, спортын хамтлаг шалгаруулах болзлын дагуу 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдөр “Олон улсын худалдаа логистикийн төв” ХК, “Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын клубүүд “Нийслэлийн шилдэг биеийн тамир, спортын клуб”-ээр шалгаруулан өргөмжлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.



НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БИЕЙН ТАМИРЫН БАГШ НАРТ ЗОРИУЛСАН ОНОЛ, ПРАКТИКИЙН СУРГАЛТ

Биеийн тамир, спортын тухай хууль, Нийслэлийг хөгжүүлэх 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш нарт зориулсан онол практикийн сургалтыг Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоотой хамтран 2025 оны 02 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт цогцолборт зохион байгуулж 9 дүүргийн 80 сургуулийн 130 биеийн тамирын багш нар хамрагдлаа.



НИЙСЛЭЛИЙН ӨВЛИЙН СПОРТЫН НААДМЫН НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг хөгжүүлэх 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/132 дугаар захирамжаар иргэдийн дунд нийслэлийн өвлийн спортын наадмын нээлтийг 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдөр 11:00-17:00 цагийн хооронд “Скай ресорт” цанын баазад Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Монголын Спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоо, “Жаргалант” уулчдын клубтэй хамтран зохион байгууллаа.

Наадмын нээлтийн арга хэмжээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нутгийн захиргааны байгууллагуудын 800 гаруй ажилтан, албан хаагч, нийслэлийн иргэд оролцсон.



НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДЫН ХӨГЖӨӨН ДЭМЖИГЧДИЙН ТЭМЦЭЭН

Улаанбаатар хотын 2025 оны аварга шалгаруулах ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын Хөгжөөн дэмжигчдийн тэмцээнийг Монголын Спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоотой хамтран 2025 оны 04 дүгээр сарын 01-20-ны өдрүүдэд 3 насны ангиллаар, 3 үе шаттай амжилттай зохион байгуулж нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын 48 сургуулийн 188 багийн 3000 сурагч оролцсон.

Хөгжөөн дэмжигчдийн нийслэлийн шигшээ тэмцээнийг 2025 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр “Буянт-Ухаа” спортын ордонд зохион байгуулж, 8 дүүргийн 54 сургуулийн 64 багийн 1024 сурагч ур чадвар, авьяасаа сорин өрсөлдсөн.



УЛААНБААТАР ХОТЫН 2025 ОНЫ АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН УРАН ХӨДӨЛГӨӨНТ ГИМНАСТИКИЙН ТЭМЦЭЭН

Сургуулийн өмнөх насны хүүхдийн бие бялдрыг гимнастикийн дасгал хөдөлгөөнөөр хөгжүүлэх, тэднийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор цэцэрлэгийн хүүхдүүдийн Уран хөдөлгөөнт гимнастикийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан.

Тэмцээнийг 2 үе шаттай зохион байгуулагдаж, анхан шатны буюу дүүргүүдийн аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 04 дүгээр сарын 05-ны дотор зохион байгуулж 9 дүүргийн 79 цэцэрлэгийн 2439 хүүхэд оролцсон бол нийслэлийн шигшээ тэмцээнийг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр “Буянт Ухаа” спортын ордонд зохион байгуулж, 9 дүүргийн 22 цэцэрлэгийн 660 хүүхэд багачууд ур чадвар, авьяасаа сорин өрсөлдлөө.



ХҮН АМЫН БИЕ БЯЛДРЫН ХӨГЖИЛ ЧИЙРЭГЖИЛТИЙН ТҮВШИН ТОГТООХ СОРИЛ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн дагуу бие бялдын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг Нийслэл, дүүргийн хэмжээнд зохион байгуулж 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 606 байгууллагыг 80792 иргэн хамрагдсан байна.

Сорилд хамрагдсан хүмүүсийн: 37 % нь- А, 30 % нь- В, 13 % нь- С, 5 % нь- D, 15 % нь- F үнэлгээ авсан ба нийт 80% нь А,В,С үнэлгээ байна байна Сорилд хамрагдсан иргэний мэдээлэл, чанарын үзүүлэлтийг www.cpanel.sport.gov.mn сайтад шивж оруулах ажил үргэлжилж байна.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ИВЭЭЛ ДОР ЗОХИОН БАЙГУУЛАХ ИРГЭДЭД ЗОРИУЛСАН “АЛХАЦГАА ГҮЙЦГЭЭ” ХӨДӨЛГӨӨН

Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас хөнгөн атлетикийн суурьтай дасгал хөдөлгөөнөөр иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээг хүргэх зорилгоор “Алхацгаа гүйцгээ” хөдөлгөөнийг нийслэлийн хэмжээнд 2025 оны 05 дугаар сарын 30-наас 10 дугаар сарын 01-ний хүртэлх хугацаанд өрнүүлж, сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Бямба гаригт иргэд нийтийн алхалт, биеийн тамирын дасгал хөдөлгөөнөөр хичээллүүлэх ажлыг зохион байгуулсан.

Удирдамжийн хүрээнд Нийслэлийн 9 дүүргүүд ажлын байрны дасгал, шугаман бүжиг, аэробик, хийн дасгал, алхалт, гүйлтийн арга хэмжээг иргэдийн дунд 21 арга хэмжээг зохион байгуулж жилийн эцсээр нийт давхардсан тоогоор 20 байгууллагын 40500 иргэнийг хамруулсан.

“ДУГУЙТАЙ УЛААНБААТАР-2025” АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Дугуйтай Улаанбаатар-2025” арга хэмжээг зохион байгуулах тухай А/564 дүгээр захирамжийн дагуу Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин ахлуулсан 25 албан хаагчдын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан 82 үйл ажиллагаа бүхий бэлтгэл ажлын төлөвлөгөөг 2025 оны 04 дүгээр сарын 14-нд батлан, хэрэгжилт 100 хувьтай байсан.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/564 дүгээр захирамжийн дагуу Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Монголын дугуйн холбоо хамтран “Дугуйтай Улаанбаатар-2025” арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсан.

“Дугуйтай Улаанбаатар-2025” арга хэмжээний хүрээнд 5км-ийн дугуйн парад, 13 насны ангиллаар тойрог замын дугуйн уралдаан, тэнцвэр дугуйн уралдааныг зохион байгуулж, 2000 иргэдийг хамруулсан байна.



“УЛААНБААТАР МАРАФОН-2025” ОЛОН УЛСЫН ГҮЙЛТ

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хууль, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Монгол улсад гүйлтийн спортыг хөгжүүлэх, гүйлтээр хичээллэгч, сонирхогч иргэдийн тоог нэмэгдүүлэх, өсвөр, залуу үеийнхэнд өөрийн дотоод нөөц боломжийг нээж, зорилгодоо хүрэх тэсвэр хатуужил, бие бялдрын болон оюун санааны өв тэгш хүмүүжлийг төлөвшүүлэх, иргэдийг өдөр тутмын биеийн тамираар хичээллэх идэвх санаачилгыг дэмжих зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/402, А/565, А/649 дүгээр захирамжийн дагуу “Улаанбаатар марафон 2025” олон улсын гүйлтийг 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр 10 дахь жилдээ амжилттай зохион байгуулсан.



“Улаанбаатар марафон 2025” олон улсын гүйлтийг 42 км 18-аас дээш нас, ХБИ, гар дугуйн уралдаан, 21 км-ийн зайг 18-34, 35-54, 55-аас дээш нас, ХБИ, 5 км-ийн зайг 12-17 нас, 18-аас дээш насны эрүүл мэндийн гүйлт, 1,5 км (хараагүйны бэрхшээлтэй, тэргэнцэртэй гэр бүл) 400м, 800м-ийн зайг тусгай олимпын тамирчид гэсэн ангиллаар тус тус зохион байгуулж нийт 27789 иргэд цахимаар, 2211 иргэн, ивээн тэтгэгч байгууллагын төлөөлөл бүртгүүлэн нийт 30000 иргэн оролцсон.

“ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР”-Т ЗОРИУЛСАН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/727 дугаар захирамжийн дагуу “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-т зориулсан тэнцвэрт дугуй, дугуй, “Аав ээж би”, хип поп бүжгийн тэмцээнийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдөр 08:00-17:00 цагийн хооронд Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсан.

Биеийн тамир, спортын арга хэмжээг Монголын дугуйн холбоо, Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоо, Монголын хип поп чөлөөт бүжгийн холбоодтой хамран зохион байгуулж нийт 2000 гаруй хүүхэд оролцсон.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/727 дугаар захирамжийн дагуу 18,361,000 төгрөгийг санхүүжүүлэх гэрээг хэрэгжилтийг ханган ажилласан.



СПОРТ, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН ХЭЛТЭС